

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 36 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны арван хоёрдугаар сарын 18-ны 14 цаг 03 минутад эхэлж, 16 цаг 07 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 04 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p> <ul style="list-style-type: none">- УИХ-ын Тамгын газрын сул орон тоо нөхөх- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын сул орон тоог нөхөх- Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагын сул орон тоог нөхөх	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <ol style="list-style-type: none">1. Улсын Их Хурлын Тамгын газрын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн Бариушановын Ариунааг “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэж, өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.2. Нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн

		<p>албан тушаалд томилохыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатарт үүрэг болгосугай.</p> <p>3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Нийслэлийн болон Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнг дараагийн хуралдаанаар хэлэлцэхээр тогтов.</p>
2	<p>"Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн ерөнхий менежерийн албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-ийн "б"-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Халзангийн Балжмааг Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн Ерөнхий менежерийн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гарган, Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн захирагч Ч.Чимэдсүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Цагдаагийн ерөнхий газарт ажиллаж байгаа Цагдаагийн ахмад А.Батсүхээс гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p>	<p>Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн ахмад А.Батсүхээс Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн "А.Батсүхээс</p>

		<p>гаргасан гомдлыг хянан шийдвэрлэсэн тухай” 2014 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 24 дүгээр тогтоолыг эс зөвшөөрч Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.5, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын “Нэг” дэх хэсгийн 3.6, 20-д заасныг удирдлага болгон:</p> <ol style="list-style-type: none">1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 459 дүгээр тушаалын А.Батсүхэд холбогдох хэсгийг хууль зүйн үндэслэлгүй байна гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх2. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 459 дүгээр тушаалын А.Батсүхэд холбогдох хэсгийг хүчингүйд тооцох3. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 459 дүгээр тушаалын А.Батсүхэд холбогдох хэсгийг <i>ооооюү сүеи үиäүñеүёоүе äíëïðüä</i> <i>õүёуүí çеâøөөðñүäүé</i> гэж шийдвэрлэсэн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн “А.Батсүхээс гаргасан гомдлыг хянан шийдвэрлэсэн тухай” 2014 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 24 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцох.4. Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаас гарсан тогтоолыг Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр
--	--	--

		<p>зүйлийн 39.6-д заасны дагуу биелүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Газрын харилцаа, геодези зураг зүйн газарт ажиллаж байсан Д.Нямжаргалаас гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p>	<p>“Ажлаас халах тухай” Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Б/133 дугаар тушаалыг эс зөвшөөрч тус агентлагийн Захиргаа, хяналт шинжилгээний хэлтсийн даргаар ажиллаж байсан Д.Нямжаргалаас Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1; 39.5 болон Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын “Нэг” дэх хэсгийн 3.4-ын “д”-д заасныг удирдлага болгон:</p> <p>1.“Ажлаас халах тухай” Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Б/133 дугаар тушаалыг хууль зүйн үндэслэлгүй байна гэж үзсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх</p> <p>2.“Ажлаас халах тухай” Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Б/133 дугаар тушаалыг хүчингүйд тооцох</p> <p>3.Тус агентлагийн үйл ажиллагаанд шалган зааварлах ажлыг зохион байгуулж, дүнг 2015 оны 2</p>

		дугаар сард багтаан Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
5	Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж, арга зүйн зөвлөгөө өгсөн тухай танилцуулах	Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилттэй танилцах зорилгоор Нийслэл дэх Салбар зөвлөл, нийслэл дүүргийн Тамгын газар, зарим төрийн байгууллагуудад ажилласан Ажлын хэсгийн дүнг сонсоод илэрсэн зөрчлүүдийг нэг сарын дотор арилгах хугацаатай үүрэг өгөх, Салбар зөвлөлд зөвлөмж хүргүүлэх нь зүйтэй гэж үзэв. Нийслэлийн Салбар зөвлөлд энэ дүнгийн талаар ярилцаж дүгнэхийг зөвлөлөө.
6	Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам батлах тухай	Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам батлах тухай асуудлыг хэлэлцээд шинэчлэгдэх эрх зүйн орчинд нийцүүлэн, улам боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзэв

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

